



Хэвлэлийн мэдээ
2017 оны 05-р сарын 29

Холбоо барих:
+976 9710-9009

Олон улсын санхүүгийн байгууллагуудын удирдлагууд АмЧамын гишүүдтэй уулзлаа

УЛААНБААТАР, Монгол улс – 2017 оны 5-р сарын 26-нд Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) нь Монгол дахь олон улсын санхүүгийн байгууллагуудын (ОУСБ) удирдлагуудтай уулзалт зохион байгууллаа. Уулзалтанд Дэлхийн Банкны Монгол дахь Суурин төлөөлөгч Жэймс Андерсон; Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Монгол дахь Суурин төлөөлөгч Ирина Кравченко; Азийн Хөгжлийн Банкны Ахлах эдийн засагч Деклан Магги; болон Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Монгол дахь Суурин төлөөлөгч Нейл Сакер нар илтгэгчээр оролцож АмЧамын ТУЗ-ийн гишүүн бөгөөд Ай Эн Жи банкны Монгол дахь төлөөлөгч Эрик Версавел чиглүүлэгчээр оролцсон юм.

Энэхүү уулзалтад АмЧамийн гишүүн байгууллагуудын удирдах түвшний төлөөлөгчид оролцлоо. Зочин илтгэгч нар ОУВС-ийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн (ӨСХ) Монгол улс, хувийн хэвшилд үзүүлэх нөлөө, ОУСБ-ын хөтөлбөрүүд нь хэрхэн ӨСХ-тэй уялдаж байгаа, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай алхамууд болон Монгол улсын санхүүгийн салбарт дунд хугацаанд үзүүлэх нөлөө ээргийн талаар илэн далангуй санал солилцож ярилцлаа.

АмЧам нь Монгол улсын санхүүгийн салбарын хөгжилд зохих хувь нэмрээ оруулах ажлын хүрээнд АмЧамын Санхүүгийн салбарын хорооноос тус уулзалтыг зохион байгуулсан юм.

ОУВС-ийн Суурин төлөөлөгч Нейл Сакер хэлсэн үгэндээ “Энэхүү хөтөлбөр нь иж бүрэн ба нэг анхааран ажиллах чиглэл бол Монгол улсын төрийн санхүүгийн удирдлагыг зохистой болгох нэн ялангуяа төсвийн зарлагын сахилга батыг сайжруулах бодлогын арга хэмжээг дэмжих явдал байх болно.” гэдгийг онцлон тэмдэглэсэн юм.

Дэлхийн Банкны Монгол дахь Суурин төлөөлөгч Жэймс Андерсон хэлсэн үгэндээ Дэлхийн Банк нь Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэх бодлогын реформыг дэмжин техникийн дэмжлэг үзүүлэх болно гэв.

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Монгол дахь Суурин төлөөлөгч Ирина Кравченко ЕСБХБ нь Монгол улсад хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн өсөлтийг дэмжиж, хувийн хэвшилд санхүүжилт үргэлжлүүлэн олгоно гэдгийг онцлов.

Азийн Хөгжлийн Банкны Ахлах эдийн засагч Деклан Магги ОУВС-ийн хөтөлбөр батлагдсанаар уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдэх бөгөөд АХБ бодлогын болон төслийн санхүүжилтийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх болно гэдгийг цохон тэмдэглэв.

АмЧамын ТУЗ-ийн гишүүн бөгөөд Ай Эн Жи банкны Монгол дахь төлөөлөгч Эрик Версавел уулзалтыг хааж хэлэхдээ “АмЧам Монгол нь өнөөдөр ОУСБ-ын тэргүүнүүд санал бодлоо хуваалцсанд баяртай байна. Цаашид бидний зүгээс Монгол улсын өмнө тулгарч буй эдийн засаг, төсөв санхүүгийн сорилтыг даван туулахад бүх талуудтай хамтран ажиллах болно” гэв.



АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбарын статустай. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.